



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

“Хүүхдийн урлагийн их наадам” арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/20 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд өсвөр үеийнхэнд Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх, өвлүүлэх, сурталчлах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, харилцан суралцах, хамтран уран бүтээл туурвих Монгол Улсаас ЮНЕСКО-д бүртгүүлсэн соёлын өвийг хүүхэд багачуудад өвлүүлж, Монгол үндэстний соёл урлаг, зан заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, соёлын солилцоог хөгжүүлэх зорилгоор “Хүүхдийн урлагийн их наадам”-ыг дүүргийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээ зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах төсвийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Г.Нарангэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА